



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/100

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны хэрэгцээнд шаардлагатай автомашины аккумулятор" нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны  
дарга:

Н.Баттөр

(Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны дарга)

Гишүүд:

Ж.Энхбадрах

(Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны Техник үйлчилгээ, засварын хэсгийн засварын инженер)

Х.Энхбат

("Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөл" Төрийн бус байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

С.Цогзолмаа

("ХУД Яармаг" Төрийн бус байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

Нарийн бичгийн  
дарга:

Б.Сумъяажав

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

17130 0467

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Н.Баттөр)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Сумъяажав)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА